



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/396

Булган сум

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндэсний бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Үндэсний бичиг үсгийн баяр-2023” аяныг зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.

2. “Үндэсний бичиг үсгийн баяр-2023” аяныг зохион байгуулахад шаардагдах 3,130,000 (гурван сая нэг зуун гучин мянга) төгрөгийг “Шинэ Ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ